



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/44/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2023 он

Миндуг Аудит ХХК
Гүйцэтгэх захирал С.Энхтөр
Утас: 95957791
Цахим хаяг: director@mindug.mn

Аудитын менежер Ц.Номингоо
Утас: 90098901
Цахим хаяг: coo@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	Error! Bookmark not defined.
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Зөвлөмж.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
УТХО	Улсын Төсвийн Хөрөнгө Оруулалт

СҮХБААТАР АЙМГИЙН ТҮВШИНШИРЭЭ
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ц.РЕНЧИНМЯДАГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойшхи үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,210,701.2 мянган төгрөг болж, 175,046.6 мянган төгрөгөөр буюу 14.5%-иар өссөн нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 20,000.0 мянган төгрөгийн цагдаагийн автомашин, 68,800.0 мянган төгрөгөөр бохирын автомашин болон 110,100.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө тус тус худалдан авч бүртгэснээс шалтгаалсан байна.

Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотойгоор Сүхбаатар аймгийн орон нутгийн өмчийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 403 тоот зөвшөөрлөөр 69 нэр төрлийн 32,204.4 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данснаас хассанаас өөрөөр санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 10 зорилго, 10 зорилтын хүрээнд 36 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг 86.87 хувьтай байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	36 486 444,63	42 699 361,00
33	АВЛАГА	4 367 543,33	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1 107 463,33	-
335	Бусад авлага	3 260 080,00	-
3351	Байгууллагаас авах авлага	3 260 080,00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	32 118 901,30	42 699 361,00
354	Хангамжийн материал	27 298 901,30	18 159 361,00
35410	Бичиг хэргийн материал	2 932 686,00	3 171 986,00
35420	Аж ахуйн материал	8 122 595,00	7 728 195,00
35430	Сэлбэг хэрэгсэл	4 511 500,00	2 000 000,00
35440	Түлш, шатах тослох материал	1 708 677,30	351 780,00
35470	Бусад хангамжийн материал	10 023 443,00	4 907 400,00
35600	Мал амьтад	4 820 000,00	24 540 000,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1 035 654 570,55	1 210 701 182,33
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1 035 654 570,55	1 210 701 182,33
392	Биет хөрөнгө	998 888 570,55	1 150 178 848,97
39201	Барилга, байгууламж, орон сууц	412 437 940,00	479 282 514,00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(90 519 116,00)	(109 400 241,07)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	367 654 496,00	456 454 496,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(196 272 238,52)	(234 479 257,66)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	183 250 866,48	159 860 956,88
39206	Хуримтлагдсан элэгдэл	(151 514 687,68)	(135 181 381,51)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17 737 804,77	15 231 064,77
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14 628 729,22)	(11 555 630,08)
39214	Бусад үндсэн хөрөнгө	844 067 751,00	954 167 751,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(373 325 516,28)	(424 201 423,36)
393	Биет бус хөрөнгө	36 766 000,00	60 522 333,36
39303	Бусад биет бус хөрөнгө	37 166 000,00	58 994 000,00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(400 000,00)	(400 000,00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1 072 141 015,18	1 253 400 543,33
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2 840 659,30	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2 840 659,30	-
413	Өглөг	2 840 659,30	-
4136	Бусад өглөг	2 840 659,30	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1 069 300 355,88	1 253 400 543,33
51	Засгийн газрын хувь оролцоо	1 069 300 355,88	1 253 400 543,33
511	Засгийн газрын оруулсан капитал/Засгийн газрын сан/ орон нутгийн сан	352 745 294,19	352 745 294,19
51101	Өмч: - төрийн	352 745 294,19	352 745 294,19
512	Хуримтлагдсан үр дүн	614 913 223,25	799 013 410,70
51210	Өмнөх үеийн үр дүн	614 913 223,25	614 913 223,25
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	101 641 838,44	101 641 838,44
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1 072 141 015,18	1 253 400 543,33

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Үзүүлэлт	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	865 362 004,00	957 686 234,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	269 736 070,00	289 012 574,00
120	Нийтлэг татварын бус орлого	269 736 070,00	289 012 574,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	269 736 070,00	289 012 574,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3 646 500,00	685 000,00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	266 089 570,00	288 327 574,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	595 625 934,00	668 673 660,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	131 272 034,00	115 730 660,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1 237 086,00	100 399 200,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31 393 940,00	15 331 460,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	464 353 900,00	552 943 000,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага/	464 353 900,00	552 943 000,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	603 820 874,52	773 586 046,55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	603 820 874,52	773 586 046,55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	588 326 605,57	720 651 204,42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	286 451 358,10	294 686 014,39
210101	Үндсэн цалин	210 629 094,94	218 460 545,23
210102	Нэмэгдэл	50 563 264,06	54 424 331,63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	6 564 162,67
210104	Урамшуулал	7 811 999,20	15 236 974,86
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37 385 702,59	37 179 859,29
210201	Тэтгэврийн даатгал	26 922 002,59	25 251 659,29
210202	Тэтгэмжийн даатгал	2 082 400,00	2 946 400,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2 603 200,00	2 395 300,00
210204	Ажилгүйдлийн даатгал	520 800,00	835 145,74
210205	Эрүүл мэндийн даатгал	5 257 300,00	5 751 354,26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31 324 554,36	23 433 996,92
210301	Гэрэл, цахилгаан	5 050 008,36	6 659 671,52
210302	Түлш, халаалт	12 967 106,00	10 405 865,40
210303	Цэвэр, бохир ус	13 307 440,00	6 368 460,00
2104	Хангамж, бараа материалын зардал	37 216 734,00	51 033 365,60
210401	Бичиг хэрэг	5 626 020,00	4 147 100,00
210402	Тээвэр, шатахуун	28 360 104,00	41 628 875,60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 729 290,00	2 430 390,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	175 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1 501 320,00	2 652 000,00
2105	Нормативт зардал	2 208 300,00	3 325 000,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2 208 300,00	3 325 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9 811 700,00	13 037 396,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4 800 000,00	10 037 396,00

210604	Урсгал засвар	4 665 000,00	3 000 000,00
2107	Томилолт, зочны зардал	6 173 000,00	6 000 000,00
210702	Дотоод албан томилолт	6 173 000,00	6 000 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10 873 576,60	44 588 105,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9 298 490,60	40 699 652,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	416 836,00	308 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	54 450,00	610 575,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	95 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2 208 500,00
210807	Газрын төлбөр	-	572 378,00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	364 450,00	50 000,00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	464 400,00	44 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	166 881 679,92	247 367 467,22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	65 795 650,07	125 327 905,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	745 500,00	1 156 600,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	100 340 529,85	120 882 962,22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15 494 268,95	52 934 842,13
2132	Бусад урсгал шилжүүлэг	13 914 955,00	37 383 172,00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6 235 355,00	6 087 672,00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5 878 600,00	12 553 200,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	16 912 300,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1 801 000,00	1 830 000,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	15 551 670,13
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	15 551 670,13
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	261 541 129,48	184 100 187,45
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	261 541 129,48	184 100 187,45

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	602 294 745,00	669 358 660,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	685 000,00
120	Нийтлэг татварын бус орлого	-	685 000,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	685 000,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	685 000,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	602 294 745,00	668 673 660,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	137 940 845,00	115 730 660,00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1 020 000,00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	104 289 819,00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1 237 086,00	100 399 200,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31 393 940,00	15 331 460,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	464 353 900,00	552 943 000,00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	464 353 900,00	552 943 000,00
1330	Төсвийн захирагчдаас	-	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	-
2	НИИТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	605 941 245,00	592 201 660,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	605 941 245,00	592 201 660,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	489 576 351,05	539 231 817,87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	286 451 358,10	294 876 810,35
210101	Үндсэн цалин	210 429 094,94	221 759 554,90
210102	Нэмэгдэл	50 763 264,06	52 071 857,91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	4 273 669,39
210104	Урамшуулал	7 811 999,20	16 771 728,15
210105	Гэрээт ажлын хөлс	17 446 999,90	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37 385 702,59	35 881 600,00
210201	Тэтгэврийн даатгал	26 922 002,59	23 905 900,00
210202	Тэтгэмжийн даатгал	2 082 400,00	2 993 900,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2 603 200,00	2 395 300,00
210204	Ажилгүйдлийн даатгал	520 800,00	641 460,71
210205	Эрүүл мэндийн даатгал	5 257 300,00	5 945 039,29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32 585 840,36	27 041 159,52
210301	Гэрэл, цахилгаан	5 050 008,36	6 659 671,52
210302	Түлш, халаалт	13 246 000,00	14 936 728,00
210303	Цэвэр, бохир ус	14 289 832,00	5 444 760,00
2104	Хангамж, бараа материалын зардал	28 451 531,00	29 474 170,00
210401	Бичиг хэрэг	5 065 000,00	2 862 300,00
210402	Тээвэр, шатахуун	20 039 121,00	22 206 480,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 797 410,00	2 430 390,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	175 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1 550 000,00	1 800 000,00
2105	Нормативт зардал	1 500 000,00	750 000,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1 500 000,00	750 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9 646 700,00	14 732 600,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4 800 000,00	11 482 600,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	346 700,00	250 000,00
210604	Урсгал засвар	4 500 000,00	3 000 000,00
2107	Томилолт, зочны зардал	6 173 000,00	6 000 000,00
210702	Дотоод албан томилолт	6 173 000,00	6 000 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11 265 006,00	57 059 696,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10 518 770,00	52 988 667,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	416 836,00	308 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	54 450,00	610 575,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	274 950,00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	95 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	2 388 500,00
210807	Газрын төлбөр	-	574 954,00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	50 000,00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	44 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76 117 213,00	73 415 782,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75 117 213,00	71 015 782,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1 000 000,00	2 400 000,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	116 364 893,95	52 969 842,13
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	13 873 000,00	36 418 172,00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6 193 400,00	6 122 672,00

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5 878 600,00	12 553 200,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	16 912 300,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1 801 000,00	830 000,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	16 551 670,13
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	1 000 000,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	15 551 670,13
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1 579 313,95	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1 579 313,95	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	100 912 580,00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3 260 080,00	-
213504	Хөрөнгийн	97 652 500,00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(3 646 500,00)	77 157 000,00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	77 157 000,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	77 157 000,00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	77 157 000,00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	77 157 000,00
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(77 157 000,00)
14	Бусад эх үүсвэр	-	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	-	-
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(3 646 500,00)	0,00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	352 745 294,19	101 641 838,44	251 745 225,86	706 132 358,49
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	352 745 294,19	101 641 838,44	251 745 225,86	706 132 358,49
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	261 541 129,48	261 541 129,48
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	352 745 294,19	101 641 838,44	614 913 223,25	1 069 300 355,88
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	352 745 294,19	101 641 838,44	614 913 223,25	1 069 300 355,88
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-

D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	184 100 187,45	184 100 187,45
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	352 745 294,19	101 641 838,44	799 013 410,70	1 253 400 543,33

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	552 943 000,00	529 004 049,87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	552 943 000,00	529 004 049,87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	515 495 600,00	492 585 877,87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	299 392 300,00	294 876 810,35
210101	Үндсэн цалин	218 247 400,00	221 759 554,90
210102	Нэмэгдэл	59 518 500,00	52 071 857,91
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5 950 000,00	4 273 669,39
210104	Урамшуулал	15 676 400,00	16 771 728,15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37 318 700,00	35 881 600,00
210201	Тэтгэврийн даатгал	25 343 000,00	23 905 900,00
210202	Тэтгэмжийн даатгал	2 993 900,00	2 993 900,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2 395 300,00	2 395 300,00
210204	Ажилгүйдлийн даатгал	598 700,00	641 460,71
210205	Эрүүл мэндийн даатгал	5 987 800,00	5 945 039,29
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22 596 400,00	22 596 399,52
210301	Гэрэл, цахилгаан	6 596 400,00	6 659 671,52
210302	Түлш, халаалт	15 000 000,00	14 936 728,00
210303	Цэвэр, бохир ус	1 000 000,00	1 000 000,00
2104	Хангамж, бараа материалын зардал	22 642 300,00	22 612 690,00
210401	Бичиг хэрэг	2 617 300,00	2 617 300,00
210402	Тээвэр, шатахуун	15 650 000,00	15 650 000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2 400 000,00	2 370 390,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	175 000,00	175 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1 800 000,00	1 800 000,00
2105	Нормативт зардал	750 000,00	750 000,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	750 000,00	750 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22 850 000,00	14 732 600,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19 600 000,00	11 482 600,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	250 000,00	250 000,00
210604	Урсгал засвар	3 000 000,00	3 000 000,00

2107	Томилолт, зочны зардал	6 000 000,00	6 000 000,00
210702	Дотоод албан томилолт	6 000 000,00	6 000 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	73 545 900,00	56 449 696,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68 153 000,00	52 378 667,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540 000,00	308 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	765 000,00	610 575,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	84 000,00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	95 000,00	95 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2 391 000,00	2 388 500,00
210807	Газрын төлбөр	1 407 000,00	574 954,00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50 000,00	50 000,00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	60 900,00	44 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30 400 000,00	38 686 082,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28 000 000,00	36 286 082,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2 400 000,00	2 400 000,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37 447 400,00	36 418 172,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	37 447 400,00	36 418 172,00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	6 123 000,00	6 122 672,00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12 553 200,00	12 553 200,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16 912 300,00	16 912 300,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1 858 900,00	830 000,00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	557 943 000,00	553 628 000,00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	557 943 000,00	552 943 000,00
132001	Орон нутгийн төсвөөс	557 943 000,00	552 943 000,00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	685 000,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	685 000,00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27	30
620001	Удирдах ажилтан	3	3
620002	Гүйцэтгэх ажилтан	7	7
620003	Үйлчлэх ажилтан	13	13
620004	Гэрээт ажилтан	4	7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	46 645 940,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	46 645 940,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	46 645 940,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	4 444 760,00
210303	Цэвэр, бохир ус	-	4 444 760,00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	6 861 480,00
210401	Бичиг хэрэг	-	245 000,00
210402	Тээвэр, шатахуун	-	6 556 480,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	60 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	610 000,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	610 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	34 729 700,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	34 729 700,00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	115 730 660,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	115 730 660,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	100 399 200,00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	15 331 460,00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын тамгын газар нь орон нутгийн онцлогт нийцсэн олон тулгуурт эдийн засгийг хөгжүүлж, цахимд суурилсан төрийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэнэ. Байгууллагын чиг үүрэг нь төрийн захиргааны байгууллага бөгөөд иргэдэд төрийн анхан шатны үйлчилгээг үзүүлэн, сумын хэмжээнд бодлого хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах, иргэдэд мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, мэргэжлийн ур чадвар олгох, дээшлүүлэх сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгад нийцүүлэн зохион байгуулах үйл ажиллагаа юм.

Байгууллагын эрх зүйн орчинг боловсронгуй болгон, үйл ажиллагааг цахимжуулж, албан хаагчдын мэргэжлийн ур чадвар, ажиллах нөхцөл, удирдлагын манлайллыг дээшлүүлэх зорилт тавин ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого, чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө дунд зэрэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 181,259.5 мянган төгрөгөөр буюу 14.5%-аар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Б	1	2	3=2-1	
Мөнгөн хөрөнгө	-	-	-	
Авлага	-	-	-	
Бараа материал	32 118 901,30	42 699 361,00	10 580 459,70	24,8%
Үндсэн хөрөнгө	1 035 654 570,55	1 210 701 182,33	175 046 611,78	14,5%
Нийт хөрөнгө	1 072 141 015,18	1 253 400 543,33	181 259 528,15	14,5%
Өр төлбөр	2 840 659,30	-	- 2 840 659,30	
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1 069 300 355,88	1 253 400 543,33	184 100 187,45	14,7%
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1 072 141 015,18	1 253 400 543,33	181 259 528,15	14,5%

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,210,701.2 мянган төгрөг болж, 175,046.6 мянган төгрөгөөр буюу 14.5%-иар өссөн нь Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 20,000.0

мянган төгрөгийн цагдаагийн автомашин, 68,800.0 мянган төгрөгөөр бохирын автомашин болон 110,100.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө тус тус худалдан авч бүртгэснээс шалтгаалсан байна.

Бараа материалын үлдэгдэл 42,699.4 мянган төгрөг болж, 10,580.5 мянган төгрөг буюу 24.8 хувиар өссөн нь тус онд 25,240.0 мянган төгрөгийн малыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авсанаас шалтгаалсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 92,324.2 мянган төгрөг буюу 9.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орлого байна. Орон нутгийн төсвөөс санхүүжих урсгал үйл ажиллагааны санхүүжилт 88,589.1 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 167,765.2 мянган төгрөгөөр буюу 21.95 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс Хангамж, бараа материалын зардал 13,816.6 мянган төгрөгөөр, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 33,714.5 мянган төгрөгөөр, Бараа үйлчилгээний бусад зардал 80,485.8 мянган төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 552,943.0 мянган төгрөг, үйл ажиллагааны нэмэлт орлогоос 115,730.6 мянган төгрөг, нийт зарлагыг 661,241.6 мянган төгрөг, тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 10 зорилго, 10 зорилтын хүрээнд 36 арга хэмжээг санхүүжүүлэхээр 557,943.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 538,806.0 мянган төгрөгийг санхүүжүүлсэн байна. Үндсэн үйл ажиллагааны арга хэмжээний зардлын гүйцэтгэл 96.6 хувьтай хэрэгжсэн байна

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Зардал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт	Хувь
1	70106 80101-үндсэн үйл ажиллагааны зардал	323 463 200,00	317 217 238,00	6 245 962,00	98,1%
2	70106 80103-Гэрээгээр гүйцэтгүүлэх үйл ажиллагааны зардал	31 005 000,00	30 189 852,00	815 148,00	97,4%
3	70106 80106-Баг хорооны үйл ажиллагааны зардал	66 874 400,00	66 633 613,00	240 787,00	99,6%
4	70106 80714-Ахмад настангуудад үзүүлэх хөнгөлөлтийн зардал	6 123 000,00	6 122 672,00	328,00	100,0%
5	70106-80802-Ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардал	31 324 400,00	31 295 500,00	28 900,00	99,9%

6	70106 81102 орон нутгийн нөөц хөрөнгийн зардал	28 000 000,00	25 786 082,00	2 213 918,00	92,1%
7	70106 1701 Байгаль орчны хамгаалах нөхөн сэргээх зардал	5 000 000,00	685 000,00	4 315 000,00	13,7%
8	70106 82706 Гоц халдварт өвчний голомтын зардал	3 353 000,00	3 342 200,00	10 800,00	99,7%
9	70106 83201 Засаг даргын үйл ажиллагааны зардал	62 800 000,00	57 533 891,00	5 266 109,00	91,6%
	Нийт дүн	557 943 000,00	538 806 048,00	19 136 952,00	96,6%

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг2ийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд төсвийн байгууллагын нэмэлт санхүүжилтийн орлого 115,730.6 мянган төгрөгийн орлогыг санхүүжүүлсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд 10 хөтөлбөр, 10 зорилгын хүрээнд нийт 36 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 86.9 хувийн гүйцэтгэлтэй байна. Хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, хэмжих шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, үр дүнг хавсаргав

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Миндүг Аудит” ХХК-ийн гүйцэтгэх захирал /МНБ, аудитор/ С.Энхтөр, аудиторын туслах Д.Сарнай нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер Б.Бүзмаа, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, тус газрын Дарга, Тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 10 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов..

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 1.0 хувиар буюу 6,038.2 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,226.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹, 15.2.3²-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд нийт зардал 169,765.2 мянган төгрөг буюу 21.95%-иар нэмэгдсэн байна. Тухайлбал: Хангамж, бараа материалын зардал 13,816.6 мянган төгрөгөөр, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 33,714.5 мянган төгрөгөөр, Бараа үйлчилгээний бусад зардал 80,485.8 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд Засаг даргын үйл ажиллагааны зардал нэмэгдсэн байна.

Бараа үйлчилгээний бусад зардалд 12,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий хортон мэрэгчдийн устгал, ариутгалын бодис, 29,248.4 мянган төгрөгийн үнэ бүхий хандиваар өгсөн хивэг, өвсний төлбөр, 18,019.2 мянган төгрөгийн багаж, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, БҮТЭЗ худалдан авсан зардлууд нэмэгдсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

² сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын тамгын газар нь мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн 6.1.1.-д "...тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор байршуулах ёстой." гэж заасны дагуу цаг хугацаанд нь ил тод байршуулахаас 6 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна. Үүнээс:

1. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр)-ийг 2 дугаар сард
2. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)-г 1 ба 2 дугаар сард
3. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (Тухай бүр)-ийг 2 дугаар сард
4. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (Тухай бүр)-ийг 2 ба 7 дугаар сард тус тус хугацаа хоцроож мэдээлсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Засаг даргын тамгын газард завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нийт 97,928.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,107.5 мянган төгрөгийн төлбөрийн зөрчилд акт тогтоож, 76,261.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 20,559.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, үндсэн хөрөнгө, шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 3. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,107.5	1	1,107.5	100%
Албан шаардлага	1	20,559.5	1	20,559.5	100%
Зөвлөмж	2	-	2	-	-
Нийт дүн	4	21,667.0	4	21,667.0	100%

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Албан шаардлага

Илрүүлэлт: Тус байгууллага нь нийт 15 аж ахуйн нэгж байгууллага болон иргэдтэй холбоотой 21,536.6 мянган төгрөгийн худалдан авалтыг татварын цахим системд бүртгээгүй, и-баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-д “Бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” заалтыг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгсөн.

5.2 Зөвлөмж

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор байршуулах ёстой. Шилэн дансны цахим системд хугацаа хоцроож байршуулсан 6 мэдээлэл байна. Үүнд:

1. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр)-ийг 2 дугаар сард
2. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр)-г 1 ба 2 дугаар сард
3. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (Тухай бүр)-ийг 2 дугаар сард
4. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (Тухай бүр)-ийг 2 ба 7 дугаар сард тус тус хугацаа хоцроож мэдээлсэн.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллүүдийг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан цаг хугацаанд тогтмол мэдээлэх;

2.Зардлын ангилал

Илрүүлэлт: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал дансанд Засаг даргын үйл ажиллагааны 18,306.0 мянган төгрөгийн зардлыг, Бараа үйлчилгээний бусад зардал дансанд 3,909.1 мянган төгрөгийн Багаж техник хэрэгсэл, 4,340.0 мянган төгрөгийн Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, 9,077.2 мянган төгрөгийн БҮТЭЗ-ийн зардал, 12,000.0

мянган төгрөгийн Хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардлыг тус тус ангилал зөрүүлэн бүртгэсэн. Зардлын ангиллыг үнэн зөв хийгээгүйн улмаас дээрх зардлын дүнгүүд хэт их өссөн дүнтэй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг биелүүлээгүй харагдуулж байна.

Өгсөн зөвлөмж: Зардлын ангиллыг зардлын шинж чанараас хамааруулан ангиллыг үнэн зөв тайлагнаж, бүртгэлд тусгах:

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
татварын цахим системд бүртгээгүй, и- баримтаар нотлогдохгүй зардал	1	21,536.6	1	21,536.6	-	-	-	-	1	21,536.6	6	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/								
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн да нсны туха й хуулийн хуга ца а хоцорч мэдээлсэн	6	-					6
Зардлын а нгила л буруу та йла гна сан	1						1	
Дүн	7	-	-	-	1	-	7	-